

**МОНГОЛ, ӨВӨРМОНГОЛЫН НЭР
ТОМЬЁОГ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Авиа зүйн нэр томьёоны жишээн дээр

Liu Yue [Сарангол]
/ӨМӨЗО-ны НШУХ/

Хураангуй: Монгол улс, Өвөрмонголын монголчууд адил бусын хоёр өөр үсэг бичиг хэрэглээд 70 жил болжээ. Монгол улсад нэр томьёоны толь бичиг ихэвчлэн Орос-Монгол, Монгол-Орос, Англи-Монгол, Монгол-Орос-Англи хэлэн дээр хэвлэгдэж, Өвөрмонголд их төлөв Хятад-Монгол хэлэн дээр хэвлэгдэж байдаг. Иймээс хоёр хил дэх монгол нэр томьёоны толь бичгүүдийг харилцан ашиглахад зарим хүндрэл гарч ирдэг. Өгүүлэлд, Д.Төмөртоогоо багшийн “Хэл шинжлэлийн Нэр Томьёоны Хураангуй Толь”, На.Гончигсүрэн багш нарын “Хэлний Шинжлэлийн Нэр Томьёо” хэмээх бүтээлүүдийг ашиглаж, хэл шинжлэл дэх авиа зүйн онолын өргөн хэрэглээний нэр томьёоноос нийт 462-г харьцуулан үзэж, зөрөөтэй зүйлийг нь жишээгээр харуулж, нэг талаас хоёр хил дэх монголчуудын солилцоон дахь хүндрэлийг багасгахыг хичээсэн бол нөгөө талаас Өвөр монголчууд нэр томьёо боловсруулахдаа Монгол улсын нэр томьёо боловсруулах туршлагаас лавлалт авах зүйл байх болов уу гэдэг санаагаа дэвшүүлэв.

Түлхүүр үг: нэр томьёо, боловсруулах, орчуулах, толь бичиг, авиа зүй

Өнгөрсөн зууны 50-90-ээд оны эхэн үе хүртэл улс төрийн тодорхой шалтгааны улмаас Монгол, Өвөрмонголын хэл, соёлын солилцоо бараг тасарсан аж. 90-ээд оноос Монгол, Өвөрмонголын харилцаа сэргэн хөгжих болов. Гэсэн хэдий ч Монгол улс 1946 оноос монгол бичгийг халж кирил бичгийг төрийн албан ёсны бичиг болгон нийт даяар хэрэглэж, Харин Өвөрмонголд монгол бичгийг өнөө хэр ашигласаар байна. Ийнхүү хоёр хил дэх монголчууд хоёр өөр үсэг бичиг хэрэглээд 70 жил болж байна.

Монгол улс, Өвөрмонголд нэр томьёоны толь бичгүүд цөөнгүй хэвлэгдсэн боловч, Монгол улсад ихэвчлэн Орос-Монгол, Монгол-Орос, Англи-Монгол, Монгол-Орос-Англи хэлэн дээр хэвлэгдэж, Өвөрмонголд их төлөв Хятад-Монгол хэлэн дээр хэвлэгдэж байдаг. Ийм ч учраас хоёр хил дэх монгол нэр томьёоны толь бичгүүдийг харилцан ашиглахад зарим хүндрэл гарч ирдэг.

Сүүлийн жилүүдэд Монгол, Өвөрмонголын монгол хэлний үгийн сан, нэр томьёоны зөрөөтэй байдлын талаар эрдэмтэн, судлаачид анхааралдаа авах болов. Үүний нэг тод илрэл бол 1999 онд “Шинэ[кирил]Монгол Хятад Толь”, 2009 онд “Хятад Монгол Үгсийн Толь” хэвлүүлснийг дурдаж болох юм. Гэвч энэхүү хоёр толь бичигт Монгол, Өвөрмонголын өргөн хэрэглээний нэр томьёо орсон боловч

мэргэжлийн нарийн нэр томьёо цөөн байна.

Энд би Д.Төмөртоого багшийн “Хэл шинжлэлийн Нэр Томьёоны Хураангуй Толь”, На. Гончигсүрэн багш нарын “Хэлний Шинжлэлийн Нэр Томьёо” хэмээх бүтээлүүдийг ашиглаж, авиа зүйн нэр томьёог хооронд нь харьцуулж зөрөөтэй талыг гаргаж ирэхийг хичээсэн билээ.

Нийт авиа зүйн нэр томьёо 462-г харьцуулж, зөрөөтэй нэр томьёоноос жишээ болгон доор харьцуулан авч үзье. Үүнд:

1. Phonetics 语音学

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Experimental phonetics	Туршилтын авиа зүй	Туршилтын авианы шинжлэл	实验语音学
Historical phonetics	Түүхэн авиа зүй	Түүхэн авианы шинжлэл	历史语音学
Comparative phonetics	Харьцуулсан авиа зүй	Харьцуулсан авианы зүй	比较语音学
Theoretical phonetics	Онолын авиа зүй	Онолын авианы зүй	理论语音学
Descriptive phonetics	Товчоолсон авиа зүй	Тодорхойлсон авиа зүй	描写语音学
Phonetics variant	Авиа зүйн хувилбар	Авианы хувилбар	语音变体

“Phonetics” буюу авиа зүйг Өвөрмонголд авианы шинжлэл, авианы зүй, авиа зүй хэмээн гурван өөр янзаар орчуулан хэрэглэх нь бий. Энэ мэтчилэн нэг зүйлийг өөр өөрөөр орчуулах, нэрлэх нь нэг талаас нэр томьёог жигдлэх, хэвшүүлэхэд сөрөг нөлөөтэй. Нөгөө талаас хүмүүс ойлгож тогтоох, ашиглахад хүртэл хүндрэлтэй байдаг. Авианы шинжлэл гэдэг нэр томьёо оновчгүй биш боловч хэл шинжлэлийн үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй хэмээх нэр томьёонуудын нэг адил “зүй” гэдэг үгийг ашиглан хэрэглэх нь зүйтэй. Авианы зүй хэмээн хэрэглэх нь зүйтэй боловч харьяалахын тийн ялгал л нэр үгийг хооронд нь холбодог учраас нэр томьёо зохиоход харьяалахын тийн ялгалын ачаалал даанч их. Харьяалахын тийн ялгалыг дахин давтан хэрэглэхээс зайлсхийх нэг арга бол англи, орос, франц, герман зэрэг Европийн гол гол хэлэнд олон улсын нийтийн журмаар хэдэн үг холбон бичиж, нэг юмны нэр байгааг үзүүлдэг зарчим¹ юм. Тухайлбал: classroom, blackboard зэрэг болно. Үүний нэгэн адил Монголд хэл шинжлэл, авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүй, авиалбар зүй, утга зүй гэх мэтчилэн харьяалахын тийн ялгалыг хураан бичиж нэр томьёо бүтээдэг зарчимтай юм.

Харин “Phonetics variant” нь авиа зүйн хувилбар болно. Өвөрмонголд ашиглагдаж буй авианы хувилбар хэмээх нэр томьёо нь хятад хэлний “语音变体” хэмээх үгийг үгчлэн орчуулснаас үүдэлтэй аж. Өвөрмонголд аливаа нэр томьёог зохиож орчуулахдаа гол төлөв хятад хэлнээс орчуулдаг. Үүнд гол анхаарууштай зүйл бол нэр томьёочид орчуулан зохиох гэж байгаа нэр томьёогоо сайтар ойлгож,

¹ Чой. Лувсанжав. Англи Хэл Өөртөө Сурах Бичиг. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. УБ., 2014. 28 дахь тал

тухайн үгийг англи, латин хэлэнд хэрхэн нэрлэж байгааг мэдэж, нэр томъёоныхоо цаад агуулгыг зөв мэдэх шаардлагатай билээ.

2. Intonation 语调

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Emotive intonation	Сэтгэл хөдлөлийн аялга	Сэтгэл хөдлөлийн аяс	感情语调
Modal intonation	Баймжийн аялга	Хандлагын аяс	情态语调
Exclamatory/ vocative intonation	Дуудах аялга	Дуудах аяс	呼语调
Imperative intonation	Захирах аялга	Захирах хүсэх аяс	祈使语调
Normal/stress/ ordinary intonation	Ерийн өргөлт	Ерийн аяс	一般语调

Юуны өмнө аялга, аяс гэдэг хоёр үгийн тайлбарыг тодруулан авч үзье.

Аялага – 1. Ярихад сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлдэг ая хөг, аялга үг; сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн хэл зүйн хувьд үл хувилах үг. 2. Харийн хэл буюу бусад нутгийн ярианы өвөрмөц дуудлагад эрхшээснээр өгүүлэх байдал; сонин аялагатай ярих. 3. Ая аялгууны энгийн хэмнэл нэгж, аялагад нь тохируулах².

Аяс – 1. Хүн амьтны зан авир, төлөв байдал, аясыг нь дагах. 2. Юмны учир чанарын тухай эе зүй, юмны аясыг тааруулах, аясаар бүтэх ажил (үйлдсэн үгэлсний ёсоор хялбархнаа болох бүтэх ажил), аяс хаалга (ойрыг бодож чухам хаалганаас өөр газар хийсэн жижиг хаалга). 3. Дуу хөгжмийн ая аялгууны удаан түргэний төлөв³.

Энэхүү Intonation[语调] гэдэг нэр томъёог монголоор аялга хэмээн орчуулах нь оновчтой болно. Харин аяс хэмээн орчуулах нь хүмүүст нэн түрүүнд салхины аяс, аясыг нь дагах гэх мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Монгол хэлний аялга үг нь:

Нэгдүгээрт, хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн, сэрэл мэдрэхүйд холбогдох аялга үг;

Хоёрдугаарт, адгуус амьтныг дуудах, туухад холбогдох аялга үг;

Гуравдугаарт, яруу найраг, дуу хөгжмийн айзам хөгийг илтгэдэг аялга үг⁴ гэсэн гурван төрөлд хуваагддаг байна.

“Normal/stress/ ordinary intonation” нь ерийн аялгыг ерийн өргөлт хэмээн андуурсан байх талтай байна.

² Я.Цэвэл. Монгол Хэлний Товч Тайлбар Толь. Хоёр дахь хэвлэл. УБ., 2013. 72 дахь тал

³ Монгол Хэлний Товч Тайлбар Толь. Хоёр дахь хэвлэл. УБ., 2013. 72-73 дахь тал

⁴ Түмэнжаргал. Одоо Үеийн Монгол Хэл. Хөххот, 2009. 354-357 дахь тал

3. Tone 声调

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Tone of voice	Дууны хөг	Аяс	音调
Polytonic stress	Давхар хөгт өргөлт	Давхар аяст өргөлт	多调重音
Tonality	Дэвсгэр хөг	Дэвсгэр аяс	基调
Basic/fundamental tone	Үндсэн хөг	Үндэсэн аяс	基调 (本调)
Even/level tone	Жигд хөг	Жигд аяс	平调
Musical tone	Эгшиглэх хөг	Эгшиглэх аяс	乐调
High tone	Өндөр хөг	Өндөр аяс	高语调
Low tone	Нам хөг	Нам аяс	低降调
Rising tone	Өгсөх хөг	Өгсөх аяс	上升语调
Descending/falling tone	Уруудах хөг	Уруудах аяс	下降语调
Toneme	Хөглөвөр	Аяслабар	调位

“Intonation” хийгээд “tone” гэсэн хоёр өөр нэр томъёог “аяс” хэмээн нэг үгээр орчуулах нь учир дутагдалтай болно. Тодруулбал “Intonation”, “Tone” нь хэл шинжлэлийн хоёр өөр ойлголт юм. Хэл шинжлэлийн хятад нэр томъёоны тайлбар толинд бичсэнээр tone → 声调, intonation → 语调 гэж байна.

Tone буюу 声调 гэдэг нэр томъёо хятад хэлэнд л байдаг өвөрмөц онцлогтой. Үүнийг “Intonation”-тэй ялгалгүйгээр дутуу ойлгож, оновчгүй нэрлэж болохгүй. Дашрамд хэлэхэд “Хэлний Шинжлэлийн Нэр Томъёоны Тайлбар Толь”-д 调位 → хөглөвөр⁵ гэжээ.

4. Function 功能

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Non-phonemic sound	Авиалбарын үүрэггүй авиа	Авиалбарын чадамжгүй авиа	无音位功能音
Separable function	Салгах үүрэг	Салгах чадамж	分离功能
Distinctive function	Утга ялгах үүрэг	Утга ялгах чадамж	区别意义功能
Hyphen	Холбох үүрэг	Холбох чадамж	连接功能

“Function” хэмээх англи үгийн язгуур утга нь үүрэг болохыг толиноос мэдэж болно. “Чадамж” хэмээн орчуулсан нь хятад нэр томъёо болох “功能”-г үгчилсэн орчуулга болно. Иймээс “function” хэмээх нэр томъёог орчуулахдаа үгийн үндсэн утгыг харгалзан үүрэг хэмээн тогтоох нь зүйтэй юм.

“Хэлний шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”-д “功能分析法” буюу үйлдлээр задлах арга хэмээн орчуулжээ. Энд “function”-г үйлдэл хэмээх үгээр дүйлгэжээ. Тэгвэл “functional linguistics” буюу “功能语言学”-г “чадамж хэлний шинжлэл”, “үйлдэлч хэлний шинжлэл” хэмээсэн нь нэлээд ойлгомжгүй хийгээд оновчгүй орчуулга байна. Харин үүний оронд “үүргийн хэл шинжлэл” гэвэл

⁵ Цэцэн.Боло. Хэлний Шинжлэлийн Нэр Томъёоны Тайлбар Толь. Хөххот, 1996. 440-441 дэх тал

ойлгоход дөхөм болно.

5. Inflection, breaking 屈折

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Inflection, breaking	хугарал	нугарал	屈折
External inflection	Гадаад хугарал	Гадаад нугарал	外部屈折
Internal inflection	Дотоод хугарал	Дотоод нугарал	内部屈折

“Inflectional language” хэмээх үгийг “нугархай хэл” гэж нэрлэсээр иржээ. Нугархай хэлний гол онцлог бол дотоод нугарал (язгуур үгийн дотоод дахь авиалбарын солигдол), гадаад нугарлаар (үгийн сүүлийн хувирал) хэлний зүйн утгыг илтгэнэ. Тэгэхдээ нэг зүйлийн хувирал нь нэг буюу хэд хэдэн зүйлийн хэлний зүйн утгыг илтгэж болно⁶. Нугархай хэлийг энгийнээр язгуур үгнийхээ өмнө, дунд, хойно хэсэг бүрт хувирал үүсгэн хэл зүйн янз бүрийн утга илтгэж чаддаг уян хатан чанартай хэл гэж ойлгож болох талтай. Нугар(а)- гэдэг үгийн уян хатан чанар бүхий утга нь хугар(а) -аас илүүтэй тод учраас дээрх нэр томъёонуудыг нугарал, гадаад нугарал, дотоод нугарал гэж нэрлэж томъёолох нь зүйтэй.

6. Alveolar 齿龈

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Post-alveolar consonant	түүшийн арын гийгүүлэгч	буйлын арын гийгүүлэгч авиа	齿龈后音
Alveolar stop	түүшийн хамжих	буйлын хамжих гийгүүлэгч	齿龈塞音
Alveolo-palatal	түүш-тагнайн	буйл-тагнайн авиа	舌面前音
Palato-alveolar	тагнайн-түүшийн	тагнайн-буйлын авиа	腭龈音
Apico-alveolar	хэлний үзүүр -түүшийн авиа	хэлний үзүүр- буйлын авиа	舌尖齿龈音

Alveolar нь хятадаар хэдийгээр “буйл” гэдэг үгээр нэрлэсэн боловч, гийгүүлэгч авиаг авиалахад “буйлын ар, буйлын хамжих, буйлын шүргэх” гэвэл, шүдний буйл нь үүдэн шүдний буйл, араа шүдний буйл гэж байдаг, чухам аль шүдний буйл вэ гэдэг асуулт гарч мэднэ.

⁶ Цэцэн.Боло. Хэлний Шинжлэлийн Нэр Томъёоны Тайлбар Толь. Хөххот, 1996. 262-263 дахь тал

7. Change 渐变

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Phonetic change	Авианы хувьсал	Авианы хувирал	音变
Gradual sound-change	Авианы аажим хувьсал	Авианы аажим хувирал	语音渐变
Mutation, sudden	Авианы огцом хувьсал	Авианы огцом хувирал	语音突变
Consonantal change	Гийгүүлэгчийн хувьсал	Гийгүүлэгчийн хувирал	辅音变化
Phonemic change	Авиалбарын хувьсал	Авиалбарын хувирал	音位变化
Combinatory sound change	Нөлөөлдөн хувьсахуй	Нөлөөтөн хувирах	联音变化

Хувьс- гэдэг үг нь үйлийн өөрчлөгдөх явцыг заадаг бол хувира- нь үйлийн өөрчлөгдөх үр дүнг заадаг. Авианы хувьсал нь тодорхой цаг хугацаа хэрэгсэж үүсдэг явц бүхий үйл юм. Иймээс Change гэх нэр томъёог хувьсал гэж жигдэлье.

8. 消失

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Delabialization	Уруулшил алдрахуй	Уруулшил арилах	唇化消失
Denasalization	Хамаршил алдрахуй	Хамаршил арилах	鼻化消失
Depalatalization	Тагнайшил алдрахуй	Тагнайшил арилах	腭化消失

“Алдар(а)-” хэмээх үг нь юмсын уг шинж чанар нь аажмаар сулран алга болох үйлийн явцыг, “арил-” хэмээх үг нь юмс оршиж байснаа алга болох үр дүнг илэрхийлдэг бөгөөд ихэнхдээ муу муухай зүйл дээр хэрэглэдэг талтай.

Англи хэл	Монгол	Өвөр монгол	Хятад хэл
Syllable peak	Үеийн орой	Үеийн оргил	音节峰
Fixed stress, bound accent	Тогтвортой өргөлт	Тогтмол өргөлт	固定重音
Movable stress	Тогтворгүй өргөлт	Шилжих өргөлт	移动重音
Sound complex	Авианы цогц	Авианы бод бие	语音实体 语音具体化
Active articulators	Идэвхтэй өгүүлэх эрхтэн	Өгүүлэхийн идэвхтэй эрхтэн	积极发音器官
Passive articulators	Идэвхгүй өгүүлэх эрхтэн	Өгүүлэхийн идэвхгүй эрхтэн	消极发音器官
Divergence	Авианы ялгарал	Задрал	分化

“Оргил” хэмээх үг нь “эрдмийн оргил”, “ноён оргил” гэх мэтээр хэрэглэгдэх нь олонтоо тохиолддог билээ. Хэдий тийм боловч “үеийн оргил” хэмээн нэрлэх нь төдийлөн оновчтой биш юм. “Оргил” хэмээх энэ үгийг өндрийн өндөр гэсэн утгаар ойлгож болох билээ. Тийм ч учраас “syllable peak”-ийг “үеийн орой” хэмээх нь илүү оновчтой байж болох талтай.

“Үеийн оргил” хэмээсэн нь хятад нэр томьёоны “峰” гэдэг үгийг шууд “оргил” хэмээн үгчилэн буулгасантай холбоотой юм. Үүний нэгэн адилаар “驼峰” буюу тэмээний бөх гэсэн үгийг шууд “тэмээний оргил” хэмээн орчуулж болохгүй билээ.

Харин тогтвортой, тогтворгүй; тогтмол, шилжих хэмээх үгс нь хоорондоо эсрэг утгатай болно. Эсрэг ухагдахууныг илтгэсэн нэр томьёо тогтооё гэвэл “-гай”, “-гүй” хэлбэрт тэмдэг нэрээр нэр томьёогоо тодотгон нэрлэвэл ойлгож тогтооход хялбар байдаг. Гэхдээ “fixed stress” буюу тогтвортой өргөлт, “movable stress” буюу тогтворгүй өргөлт гэдэг нэр томьёонуудыг “тогтмол”, “шилжих” гэдгээр жигдэлье гэвэл “fixed stress” буюу тогтмол өргөлт, movable stress буюу шилжмэл өргөлт хэмээн “тогтмол”, “шилжмэл” гэсэн ижил хэлбэрт эсрэг утга бүхий хоёр тэмдэг нэрээр тодотгон нэрлэвэл болохгүй гэх газаргүй.

“Sound complex”-ийг авианы цогц хэмээсэн нь авианы бод биеийг бодвол нэр томьёо зохиох богино, авсаархан байх зарчимд нийцэх бөгөөд түүнчлэн монгол хэлний үндсэн үгийн сангийн үгээр оновчтой илэрхийлсэн байна. Харин авианы бод бие хэмээх нь шууд үгчилсэн орчуулга болох нь илэрхий байна.

“Active articulators”, “passive articulators”-ыг өгүүлэхийн идэвхтэй эрхтэн, өгүүлэхийн идэвхгүй эрхтэн хэмээх нь найруулга зүйн талаас алдаатай байна. Өгүүлэх эрхтнийг нь идэвхтэй, идэвхгүй гэж тодотгохоос биш, эрхтэн нь өгүүлэхийн идэвхтэй, өгүүлэхийн идэвхгүй гэгддэггүй.

“Divergence”-ийг “Хэл шинжлэлийн нэр томьёоны хураангуй толь”-д авианы ялгарал хэмээсэн бол “Хэл Шинжлэлийн Англи-Орос-Монгол Толь Бичиг”- т авианы салбарлал⁷ хэмээн илэрхийлжээ. “Divergence” ба “分化” нь ялгарч салбарлах гэсэн утгатай, харин “分解” хэмээвэл задрах гэсэн утгатай болно. Гэвч Монгол улсад “Divergence” гэдэг нэр томьёог авианы ялгарал ба авианы салбарлал гэж хоёр өөр янзаар нэрлэж бий. Энэ хоёрын утгын нарийн ялгаанд нь суурилан аль нэгээр нь жигдлэх шаардлагатай, ингэж ойролцоо утгат нэр томьёо зэрэгцэн явах нь нэр томьёо ойлгож тогтоох, жигдлэх, хэвшүүлэхэд сөрөг нөлөөтэй.

Монгол, Өвөрмонголын нэр томьёог харьцуулж хийсэн энэхүү ажлаа хураангуйлан бид дараах дүгнэлт хийж байна, үүнд :

(1) Авиа зүйн нэр томьёо нийт 462-г харьцуулснаас ижил нэр томьёо нь 314 буюу 67.9 %, төсөөтэй нэр томьёо нь 68 буюу 14.7 %, зөрөөтэй нэр томьёо нь 80 буюу 17.3 %-ийг тус тус эзэлж байна. Нэг үндэстэн, нэг хэл аялгуу учраас ижил нэр томьёо нь дийлэнх хувийг эзэлж байгаа, гэвч хоёр өөр соёл, хоёр өөр хэлний орчинд байгаа учраас түүний нөлөөгөөр хоёр орны нэр томьёонд бас тодорхой хэмжээний зөрөө гарсан байна.

(2) Миний ажигласнаар, зөрөөтэй байгаа нэр томьёонуудын дотроос монгол улсын боловсруулсан нэр томьёо оновчтой байх нь түлхүү шиг байна. Өвөрмонголын монгол нэр томьёо нь англи, латин хэлний нэр томьёог хятад

⁷ Д.Энхбат. Хэл Шинжлэлийн Англи-Орос-Монгол Толь Бичиг. УБ., 2003. 77 дахь тал

хэлнээс дамжуулж орчуулсан, улмаар хятад хэлнээс үгчилж орчуулснаас зарим оновчгүй буюу уул англи, латин нэр томъёоноос арай холдсон зүйл ажиглагдаж байна. Нэр томъёо боловсруулах ажилд Монгол, Өвөрмонголын нэр томъёочид бие биенээсээ суралцах буюу лавлалт авах зүйл бий.

(3) Эцэст нь хэлэхэд, хоёр орны нэр томъёочид нэр томъёоны толь бичиг найруулахдаа кирил, монгол хоёр бичигт хадаж өгөх нь зүйтэй, тэр мөртлөө мэдээлэл технологийн мэргэжилд түшиглэж, вэбсайт, компьютер, ухаалаг гар утас зэрэг цахим орчинд тавьж өргөнөөр ашиглах боломжийг нь бий болгох нь чухал байна.

ABSTRACT

It has been about 70 years since the Mongolians and the Mongolian people in Inner Mongolia of China began to use different writing characters. Terminologies in Mongolia mainly are pressed and published in Russian-Mongolian dictionaries, Mongolian-Russian dictionaries, English-Mongolian dictionaries and Mongolian-Russian-English dictionaries, whereas in Inner Mongolia of China, they are mainly published in Chinese-Mongolian dictionaries, which leads to some obstacles in the consultation and usage from each other. In this dissertation, Mongolian scholar D.Tumurtoogoo's "Thesaurus of Linguistic" and Inner Mongolian scholar Na.Gontrogsuren's "Terminologies And Linguistics" are used for main research resources, and 462 examples of common and widely-used phonetic terminologies of linguistic were chosen to be compared for their differences. This dissertation aims not only to reduce some obstacles of communication between Mongolian people of these two different areas, but also to present some references on extraction of terminologies of Mongolians for that of Inner Mongolians.

Key word: terminologies, phonetic, translate, dictionary

НОМЗҮЙ

1. Гончигсүрэн На. *Хэлний Шинжлэлийн Нэр Томъёо*. Хөххот., 2005
2. Лувсанжав Чой. *Англи Хэл Өөрөө Сурах Бичиг*. УБ., 2014
3. Төмөртоого Д. *Хэл шинжлэлийн Нэр Томъёоны Хураангуй Толь*. УБ., 2004
4. Түмэнжаргал. *Одоо Үеийн Монгол Хэл*. Хөххот., 2009
5. Цэвэл Я. *Монгол Хэлний Товч Тайлбар Толь*. УБ., 2013
6. Цэцэн. Боло. *Хэлний Шинжлэлийн Нэр Томъёоны Тайлбар Толь*. Хөххот., 1996
7. Энхбат Д. *Хэл Шинжлэлийн Англи-Орос-Монгол Толь Бичиг*. УБ., 2003
8. 冯志伟, 《语言学名词》, 北京, 2012 年